



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 8/110

Чингис хот

Б.Энх-Эрдэнийг Хэрлэн сумын Засаг дарга
бөгөөд Чингис хотын захирагчаар
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 26 дугаар зүйлийн 26.3, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны "Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ" 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж тус газрын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 05/9218 дугаар албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5. 26.5.1, 26.5.2. 26.5.3, 26.5.4. 26.5.5 дахь заалтад заасан шаардлагыг хангасан Баттулгын Энх-Эрдэнийг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагчаар 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс томилсугай.

2. Хэрлэн Сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч Б.Энх-Эрдэнийн үндсэн цалинг 1052207 /нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон/ төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар болон бусад нэмэгдлийг тооцож цалинжуулахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ